



ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛСЫН ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

(Захиргааны эрх зүйн маргаан)¹

ЦАГДААГИЙН АЛБАН ХААГЧ АЖИЛ ҮҮРГЭЭ ГҮЙЦЭТГЭХ ЯВЦДАА ЗОЧИД БУУДАЛД БЭЛЭН БАЙДАЛТАЙ БАЙРЛАЖ БАЙСАН ХУГАЦААГ АЖЛЫН ЦАГТ ТООЦОЖ, ХУУЛЬД ЗААСНЫ ДАГУУ НӨХӨН АМРААНА

САНАМЖ: Энэхүү хураангуй нь хуульч, судлаач, эрх зүйн чиглэлээр суралцагчдад болон олон нийтэд мэдээлэл өгөх зорилготой бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь гадаад улсын шүүхийн шийдвэр болно.

Шүүхийн шийдвэрийн дугаар: BVerwG 2 C 18.20

Шүүхийн шийдвэрийн огноо: 2021 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр

Шийдвэрийн агуулга: Нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, цагдаагийн албан хаагч нарын ажил, үүргээ гүйцэтгэх явцдаа зочид буудалд бэлэн байдалтай байрлаж байсан хугацааг “ажлын цаг”-т тооцож, нөхөн амрах эрхтэй гэж шийдвэрлэсэн.

ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (цаашид “ХБНГУ” гэх)-ын Бавариа мужийн Эльмау шилтгээнд 2015 оны 06 дугаар сарын 07-08-ны өдрүүдэд “Их-7” бүлгийн улсуудын дээд хэмжээний уулзалт, 09-10-ны өдрүүдэд Австри Улсын Тироль мужийн Билдербергийн уулзалт тус тус болсон. Энэхүү уулзалтуудын аюулгүй байдлыг хангах зорилгоор олон тооны цагдаагийн албан хаагчид уулзалт болох газруудад хяналтын үүрэг гүйцэтгэж байжээ.

Тухайн уулзалтуудын үеэр Холбооны Цагдаагийн Газраас албан хаагчдыг уулзалтууд болох газрын ойролцоо зочид буудалд байрлуулж, аюулгүй байдлыг хангах үүрэгтэй нь холбогдуулан зарим хязгаарлалтуудыг тогтоосон. Тухайлбал албан хаагчид тухайн зочид буудлаасаа гарч явахгүй байх, дуудсан цагт хүрч очих боломжтой байх, зэвсэг бусад хэрэгслээ тогтмол авч явах, согтууруулах ундаа хэрэглэхгүй байх зэргийг үүрэг болгож, тогтмол бэлэн байдалд байлгасан. Холбооны Цагдаагийн Газрын зүгээс албан хаагчид уулзалтууд болох газарт эргүүл хийгээд, зочид буудалдаа буцаж очин бэлэн байдалтай байрлаж байсан хугацааг ажлын цагт тооцохгүй, харин амралтын цагт тооцно гэж үзсэн. Харин албан хаагчдын зүгээс тухайн хугацааг ажлын цагт тооцох ёстой гэж маргаж, цагдаагийн алба хаагч нар ажил үүргийн хуваарьт заасан эргүүл хийсний дараах амарч буй хугацаа нь ажлын цагт хамаарах бөгөөд тухайн хугацаатай дүйцүүлэн нөхөн амрах эрхтэй гэх агуулга бүхий нэхэмжлэлийг гаргасан.

¹ Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр нь үзэх холбоос: <https://www.bverwg.de/290421U2C18.20.0>.



ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

Өмнөх шатны шүүхээс: Анхан шатны шүүхээс (герм. *Verwaltungsgericht*) цагдаагийн албан хаагч нарын зочид буудалд байрлаж байсан хугацаа нь ажлын цагт хамаарахгүй бөгөөд амралтын цагт багтана гэж үзэж, нэхэмжлэлийн шаардлагыг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн. Харин давж заалдах шатны шүүхээс (герм. *Oberverwaltungsgericht*) Холбооны Цагдаагийн Газрын тогтоосон нөхцөлд, албан хаагчдын эрх чөлөө хязгаарлагдаж байсан тул нэхэмжлэгч нар нөхөн амрах эрхтэй гэх дүгнэлт хийж, нэхэмжлэлийн шаардлагыг хангаж шийдвэрлэжээ.

Холбооны Цагдаагийн Газрын зүгээс давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг эс зөвшөөрч Холбооны Захиргааны хэргийн шүүхэд (герм. *Bundesverwaltungsgericht*) гомдол гаргасан. Ингэхдээ албан хаагчийн амралтын цаг гэдэгт эргүүл хийсний дараа зочид буудалд бэлэн байдалд амрах хугацааг хамааруулан ойлгох бөгөөд, хариуцагч маргаан бүхий асуудлаар шийдвэр гаргах эрхтэй гэж тайлбарлажээ.

Холбооны захиргааны хэргийн шүүхээс: Холбооны захиргааны хэргийн шүүхээс тухайн хэргийг шийдвэрлэхдээ нэгдүгээрт, буудалд амарч байсан хугацааг “ажлын цаг”-т тооцох эсэх, хоёрдугаарт, маргаан бүхий асуудлаар Холбооны Цагдаагийн Газар сонгох боломж (эрх)-ээ зөв зүйтэй хэрэгжүүлсэн эсэхэд тус тус дүгнэлт хийжээ. Үүнд:

1. Холбооны төрийн албан хаагчдын ажлын цагийн журам (герм. *Arbeitszeitverordnung*)²-ын 2 дахь зүйлийн 12-т “Долоо хоногийн ажлын цаг гэдэг нь арван хоёр сарын хугацаанд гүйцэтгэх долоо хоногийн дундаж ажлын цагийг хэлнэ” гэж заасны дагуу **ажилтан Холбооны Цагдаагийн Газрын заасан газарт байж, шаардлагатай үед шууд ажиллахад бэлэн байсан бол энэ нь бэлэн байдлын үүргийг илэрхийлэх бөгөөд ажиллаж буй цагт тооцогдоно.** Мөн Европын Холбооны Ажлын цагийн журам (англ. *Working time directive*)³-ын 2 дугаар зүйлийн 1-д ““ажиллах цаг” гэж “ажилчин үндэсний хууль тогтоомж болон жишгийн дагуу ажил олгогчийн мэдэлд ажиллаж, үйл ажиллагаа, үүргээ гүйцэтгэж байгаа аливаа хугацааг хэлнэ”” гэж заасан. Энэхүү үндэслэлээр цагдаа нарын хувьд эргүүл хийж байгаад амарсан хугацаа нь амралт биш, харин ажиллаж буй цагт хамаарах юм. Ийм учраас ХБНГУ-ын Төрийн албан хаагчийн тухай хууль (герм. *Bundesbeamtenengesetz*)⁴-ийн 88 дугаар зүйлд “Төрийн албан хаагчид нь зайлшгүй албаны нөхцөл байдал шаардсан тохиолдолд, нэмэлт ажил нь онцгой тохиолдолд хязгаарлагдсан байх нөхцөлтэйгөөр, долоо хоногийн тогтмол ажлын цагаас хэтрүүлэн цалин хөлсгүйгээр ажиллах үүрэгтэй. Хэрэв албан ёсоор зөвшөөрөгдсөн нэмэлт ажлыг сар бүрийн тогтмол ажлын цагаас илүү таван цагаас дээш ажилласан

² Холбооны төрийн албан хаагчдын ажлын цагийн журам, <https://www.gesetze-im-internet.de/azv/BJNR042710006.html>.

³ Европын Холбооны Ажлын цагийн журам, <https://eur-lex.europa.eu/eli/dir/2003/88/oj/eng>.

⁴ ХБНГУ-ын Төрийн албан хаагчийн тухай хууль, https://www.gesetze-im-internet.de/bbg_2009/.



- бол, нэг жилийн дотор хуулийн тухайн нэмэлт ажлын нөхөн олговор авах болон нөхөн амрах эрхтэй...” гэж заасны дагуу нөхөн амралт авах эрхтэй гэжээ.
2. Холбооны Цагдаагийн Газрын гомдолд дурдсан маргаан бүхий асуудлаар Цагдаагийн ажилтны тухай хууль (герм. *Bundespolizeibeamtengesetz*)⁵-ийн 11 дүгээр зүйлд “Холбооны цагдаагийн нэгж, бүрэлдэхүүн, дэд ангиудын нэгээс дээш хоног үргэлжилсэн байршил, сургуулилтын хувьд Холбооны Төрийн албаны тухай хуулийн 87, 88 дугаар зүйлд заасан амралтын оронд нэгдсэн амралтыг олгоно...” гэх заалтыг үндэслэн сонгох боломжийн хүрээнд шийдвэр гаргах эрхтэй гэдгийг шүүхийн шийдвэрт дурдсан байна. **Гэхдээ тухайн сонгох боломж нь хуулийн хүрээнд, бодит нөхцөлд үндэслэн шийдвэр гаргах ёстой гэдгийг тайлбарласан. Өөрөөр хэлбэл Холбооны Цагдаагийн Газрын сонгож буй хууль зүйн үндэслэл нь албан хаагчдын хувийн ашиг сонирхолд нийцэхгүй, харин ажил олгогч Холбооны Цагдаагийн Газрын ашиг сонирхолд нийцэж байгаа бөгөөд захиргааны сонгох боломж (эрх)-ийг буруу ашиглаж⁶ буй хэлбэр** гэх агуулгаар тайлбарлажээ.

Иймээс Холбооны захиргааны хэргийн шүүх нэхэмжлэлийн шаардлагыг хангаж, “Их-7” бүлгийн улсуудын дээд хэмжээний уулзалт болон Билдербергийн уулзалтын үеэр үүрэг гүйцэтгэж байсан цагдаагийн ажилтнуудын бэлэн байдалд амарч байсан хугацаа нь ажлын цагт хамаарах бөгөөд албан хаагчид тухайн ажилласан цагийг үндэслэн нөхөн амрах эрхтэй гэж шийдвэрлэжээ.

---oOo---

⁵ ХБНГУ-ын Цагдаагийн ажилтны тухай хууль, <https://www.gesetze-im-internet.de/bpolbg/BJNR113570976.html>.

⁶ Герман хэлээр Ermessensfehlgebrauch гэх ойлголт бөгөөд шүүхийн шийдвэрт энэхүү агуулгаар оржээ.